



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 09. 27 № *21*

Г Асуулга тавих тухай

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хот төдийгүй зарим аймгийн төвүүдэд агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрч, хүний эрүүл мэнд, амь насанд ноцтой аюул заналхийлж, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэвшилд ихээхэн хохирол учруулах боллоо. Тиймээс үндэсний аюулгүй байдлын хэмжээний энэ асуудлыг бодитой шийдвэрлэж, шийдэлтэй, шийдвартэй арга хэмжээ авахын төлөө миний бие бусад гишүүдийн хамт “Утааны эсрэг” лобби бүлэг байгуулан ажиллаж байгаа билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 62 дугаар тогтоолоор утаяа, агаарын бохирдлыг багасгах зорилгоор 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ахуйн зориулалтаар хэрэглэх түүхий нүүрс оруулахыг хориглох шийдвэр гарсан.

Энэ ажлын хүрээнд “Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн дэргэд “Таван толгой түлш” ХХК-ийг байгуулан сайжруулсан түлш үйлдвэрлэж энэ өвлөөс эхлэн нийслэлийн гэр хорооллын айлуудын хэрэглээг хангахаар болсон билээ.

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын гэр хороололд 220 мянга орчим айл өрх байгаа бөгөөд жилд дунджаар 1.2 сая тонн түүхий нүүрс хэрэглэдэг гэсэн судалгаа бий. Түүхий нүүрсний хэрэглээг бүрэн халснаар жилд 600 мянган тонн шахмал түлш хэрэглэх тооцоо гарсан ба үүний үр дунд утаяа, агаарын бохирдол 50 хувиар буурна гэж үзэж байгаа.

Олон нийтийн дунд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нөөц, чанар, хуртээмж, түгээлт, хэрэглээтэй холбоотой олон асуулт, асуудлууд гарсаар байна.

Иймд Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Танд хандан тавьж байна. Үүнд:

1. “Таван толгой түлш” ХХК-ийн сайжруулсан түлшний үйлдвэрийн хүчин чадал, төлөвлөсөн норм, төлөвлөгөөний дагуу бүтээгдэхүүнээ үйлдвэрлэж чадаж байгаа эсэх, хэрхэн нөөцөлж, хадгалж байгаа талаар;
2. Хувийн хэвшлийн шахмал түлшний үйлдвэрүүдийг дэмжиж, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд хэрхэн анхаарч байгаа;
3. Сайжруулсан шахмал түлшийг иргэдэд ямар үнэ өртөгөөр, хаана, хэрхэн түгээн борлуулж байгаа талаар;
4. 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ахуйн зориулалтаар хэрэглэх түүхий нүүрс оруулахгүй байх, айл өрхүүдийн түүхий нүүрсний хэрэглээг хориглох шийдвэрийн хэрэгжилт, түүнд хэрхэн хяналт тавьж, ямар арга хэмжээ авч буй талаар;
5. Нийслэлд буй 3 мянга орчим нам даралтын зуухыг сайжруулсан шахмал түлшээр хэрхэн хангах талаар;
6. Сайжруулсан шахмал түлшийг агаарын бохирдол ихтэй бусад аймаг, орон нутагт үйлдвэрлэх, түгээх, хэрэглээнд нэвтрүүлэх нөөц боломж байгаа эсэх, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого, төлөвлөлтийн талаар;
7. Олон нийтийн дунд сайжруулсан шахмал түлш илч багатай, утаа тортог ихтэй, чанаргүй байна гэсэн санал гомдол гарч, энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээлэл хэр бодитой эсэх;
8. Хуурамч шахмал түлш үйлдвэрлэж иргэдийг хохироосон гэмт үйлдэлд ямар хариуцлага тооцсон талаар тодорхой дэлгэрэнгүй хариулт ирүүлэхийг хүсье.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

С.БЯМБАЦОГТ

УХА0317

